



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/332

Улаанбаатар хот

Навигацийн үзлэг зохион байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7.2.2.2 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/129 дүгээр тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны А/559 дүгээр тушаалаар баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа салбар, нэгжүүдийн агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний бэлэн байдлыг шалгах навигацийн үзлэг зохион байгуулах журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа салбар, нэгжүүдийн техник, тоног төхөөрөмж, аэродром, барилга байгууламжийн ашиглалтыг хавар-зуны ашиглалтаас намар-өвлийн ашиглалтад шилжүүлэх үйл ажиллагааны бэлэн байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, орон нутгийн нисэх буудлуудад навигацийн үзлэг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг хоёрдугаар хавсралтаар, төвийн салбар, нэгжүүдэд навигацийн үзлэг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг оновчтой төлөвлөж хэрэгжүүлсэн, удирдах дээд байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан харьяа салбар, нэгжийн удирдлага, ажилтнуудад үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахыг ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.


3. Навигацийн үзлэгийг холбогдох журмын дагуу зохион байгуулж, үр дүн, тайланг 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөрт багтаан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
А/32 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХАВАР-ЗУНЫ АШИГЛАЛТААС НАМАР-ӨВЛИЙН АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БЭЛЭН БАЙДАЛ, ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ШАЛГАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө батлах тухай” А/129 дүгээр тушаалын хэрэгжилт, хавар-зуны ашиглалтаас намар-өвлийн ашиглалтад шилжин ажиллах үйл ажиллагааны бэлэн байдлыг шалгах, илэрсэн үл тохирол дутагдлыг арилгах, залруулах арга хэмжээ зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгч, ажилтнуудын сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр.Хамрах хүрээ

- 2.1. Нисэх буудлын үйлчилгээний чиглэлээр
 - 2.1.1. Аэродромын үйлчилгээ
 - 2.1.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ
 - 2.1.3. Зорчигч үйлчилгээ
 - 2.1.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийн хангалт
 - 2.1.5. Өвөлжилтийн бэлтгэл ажил
 - 2.1.6. Газрын үйлчилгээ
 - 2.1.7. Агаарын хөлгийн шатахуун агуулах
- 2.2. Агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээр
 - 2.2.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ
 - 2.2.2. Холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээ
 - 2.2.3. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ
 - 2.2.4. Цаг уурын үйлчилгээ
 - 2.2.5. Цахилгаан хангалтын үйлчилгээ

2.3. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө батлах тухай” А/129 дүгээр тушаалын хэрэгжилт;

2.4. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, удирдах дээд байгууллагын албан даалгавар, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан дүгнэлт, шаардлагын хэрэгжилт;

2.5. Захиргаа, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хэрэгжилт;

2.6. Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, түүний хэрэгжилт;

Гурав.Ажлын хэсэгт

3.1. Ажлын хэсэг навигацийн үзлэгт хамрагдаж байгаа тухайн нисэх буудлын үйл ажиллагаанд тулгамдаж буй зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажлыг шуурхай шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

